Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын 2020 оны төлөвлөгөөнд нийт 41 ажил тусгагдсанаас 34 ажил бүрэн хэрэгжиж, ковид-19 цар тахлаас шалтгаалан Монгол улсад бүх нийтийн хөл хорионы онц байдал зарласан, мөн Засгийн газраас гаргасан тогтоол шийдвэрийн дагуу төлөвлөгөөт бус шалгалтууд хийсэнтэй холбоотойгоор төлөвлөгөөнд тусгасан 7 ажил хэрэгжээгүй, үнэлэх боломжгүй байна.

Дотоод аудит, хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс болон Санхүүгийн хяналт шалгалтын хэлтсээс Сангийн яамны 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Сангийн яамны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайланг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 60,756,948.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 911,354.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон, гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Сангийн яамны 2020 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,268,687.5 мянган төгрөгөөр буюу 2.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	34,752,650.1	31,783,005.3	-2,969,644.8
Авлага	172,068.4	331,735.0	159,666.6
Урьдчилж гарсан зардал	658,968.6	242,216.7	-416,751.9
Бараа материал	687,318.9	868,769.6	181,450.7
Нөөцийн бараа	2089,793.0	-	-2,089,793.0
Үндсэн хөрөнгө	21,984,564.2	27,038,795.1	5,054,230.9
Хуримтлагдсан элэгдэл	-10,746,145.7	-11,933,991.7	-1,187,846.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>49,599,217.5</b>	<b>48,330,530.0</b>	<b>-1,268,687.5</b>
Өр төлбөр	2,861,096.8	1,092,615.3	-1,768,481.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	46,738,120.6	47,237,914.7	499,794.1
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>49,599,217.5</b>	<b>48,330,530.0</b>	<b>-1,268,687.5</b>



Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 31,783,005.3 мянган төгрөг болж 2,969,644.8 мянган төгрөгөөр өмнөх оноос буурсан байна.

Тайлант онд Сангийн яамны барьцаа хөрөнгийн данс буурсан нь 14,131,897.7 мянган төгрөгийн барьцаа чөлөөлөлтөөр хасагдаж, Засгийн газрын 2020 оны “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 253 дугаар тогтоолын дагуу хэрэгжиж дуусаагүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг байршуулах тухай шийдвэр гарснаас Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Хөгжлийн хөтөч дэд бүтэц төслийн нийт 10,907,279.5 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, мөн гүйцэтгэгч 11 аж ахуйн нэгж байгууллагын барьцааны баталгаа 254,973.4 мянган төгрөг, нийт 11,162,252.9 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс голлон нөлөөлсөн байна.

Засгийн газрын тогтоолоор хэрэгжээгүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зардлаар зөвшөөрч, мөнгөн хөрөнгөд татаж үлдэгдлээр тайлагнасан нь тухайн жилийн төсвийн хөрөнгө оруулалтын зардал буруу илэрхийлэгдэх, хөрөнгө оруулалтын ажил дуусахгүй байх, үр өгөөж буурах, Төсвийн тухай хууль хэрэгжихгүй байх сөрөг үр дагавартай байна.

Авлага дансны үлдэгдэл 331,735.0 мянган төгрөг болж 159,666.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, саарал жагсаалтаас гаргах ФАТФ-ын үнэлгээний ажлын хэсгийн төлөөлөгчдийг Монгол Улсад авч ирэх МИАТ ХК-ийн тусгай нислэгийн санхүүжилтийн зөрүү 268,048.2 мянган төгрөгийн авлагаас голлон шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэлд гадаад томилолтын тийзийн үнэ 1,198.5 мянган төгрөг, МИАТ ХК-аас авах тусгай нислэгийн тийзийн үнийн зөрүү 268,048.2 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдлийг татан төвлөрүүлсэн 56,144.9 мянган төгрөг нийт 325,391.6 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулан тайлагнасан байна.

Мөн гадаад хэвлэл захиалгын төлбөр 4,814.9 мянган төгрөг, татан буугдсан Сэргээн босголт банкнаас авах он удаан жил болсон харилцах дансны үлдэгдэл 1,257.5 мянган төгрөг, ажилчдаас авах цалингийн авлага 271.0 мянган төгрөг бүртгэлтэй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байгаад анхаарал хандуулбал зүйтэй байна.

Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл 242,216.7 мянган төгрөг болж, 416,751.9 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны үлдэгдлийг зардлаар зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой боловч тайлант жилийн эцэст 2021 онд төлөх Төрийн сангийн Фрийбаланс программ, экспортын бүтээгдэхүүний үнийн мэдээлэл авах 3 программ, санхүүгийн Acolous программ, хэвлэл захиалгын төлбөр зэрэгт нийт 242,216.7 мянган төгрөгийн төлбөрийг урьдчилан төлж, тайлагнасан байна.

Энэ нь тухай жилийн Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлээгүй, Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-т “Төсвийг нэг жилээр баталж, тайлагнах бөгөөд батлагдсан төсвийг сар, улирлаар хуваарилан, хэрэгжилтийг зохион байгуулна”, санхүүгийн тайлангийн Хэмжилт батламж мэдэгдлийг хангахгүй байх сөрөг үр дагавартай байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 868,769.6 мянган төгрөг болж 181,450.7 мянган төгрөгөөр өссөн нь тус яамны хэвийн үйл ажиллагааг хангахад зориулж төсвийн хөрөнгөөр 315,726.5 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгө худалдан авснаас голлон нөлөөлсөн.

Бараа материалын дансанд 11,320.1 мянган төгрөгийн 2,079 ширхэг Нягтлан бодох бүртгэлийн тэргүүний ажилтан тэмдэг, 7,171.2 мянган төгрөгийн 1,494 ширхэг санхүү банкны тэргүүний ажилтан тэмдэг, 6,398.0 мянган төгрөгийн 914 ширхэг Сангийн яамны

хүндэт тэмдэг, 160,960.0 мянган төгрөгийн 1,238 ширхэг Монголбанк Сангийн яам дурсгалын мөнгөн тэмдэг, 13,605.0 мянган төгрөгийн 1,485 боодол бичгийн цаас, 2,217.6 мянган төгрөгийн 1,386 ширхэг цаасан тор, 1,088.7 мянган төгрөгийн 382 ширхэг яамны логотой тор зэрэг бараа материалын нөөц байна.

Нөөцийн бараа данс үлдэгдэлгүй тайлагнагдсан нь бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэлтэй яамны барилгын 3 жил, он дамжин хэрэгжсэн их засварын зардал 2,965,340.7 мянган төгрөгийг капиталжуулан үндсэн хөрөнгөд шилжүүлэн бүртгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 27,038,795.0 мянган төгрөг болж, 5,054,230.9 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 232,363.6 мянган төгрөг, гадаад зээлийн төсөл хөтөлбөрөөс үнэ төлбөргүй хүлээн авсан 1,942,508.3 мянган төгрөг, ТӨБЗГ-ын холбогдох тушаал шийдвэрээр 160,074.3 мянган төгрөг, татан буугдсан байгууллагаас шилжүүлэн авсан 302,467.5 мянган төгрөг, бусад эргэлтийн хөрөнгөөс шилжүүлэн бүртгэсэн 3,096,923.2 мянган төгрөг, нийт 5,734,336.9 мянган төгрөгөөр нэмэгдэж, ТӨБЗГ-ын холбогдох тушаал шийдвэрүүдээр 363,068.8 мянган төгрөгийн хөрөнгө акталж, бусад байгууллага болон бараа материалын дансанд шилжүүлэн бүртгэсэн 317,037.2 мянган төгрөг, нийт 680,106.0 мянган төгрөгөөр хасагдсан зэргээс шалтгаалсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1,092,615.3 мянган төгрөг болж, 1,768,481.5 мянган төгрөгөөр буурсан нь 2,299,083.2 мянган төгрөгийн барьцаа хөрөнгийг чөлөөлснөөс буурч, тайлант онд 7 төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлж буй төслүүдийн монгол талын хөрөнгө болох 30,060,933.1 мянган төгрөгийн санхүүжилтээс барьцаа хөрөнгийн дансанд суутгасан гүйцэтгэгч 7 аж, ахуйн нэгж байгууллагатай холбоотой 254,973.4 мянган төгрөг, Засгийн газрын нөөц санд төлөх 268,048.2 мянган төгрөгийн МИАТ ХК-ийн тусгай нислэгийн тийзний үнийн зөрүү, ГЕГ-ын гүйцэтгэгчээс суутгасан 7,580.3 мянган төгрөгийн Улсын төсөвт төлөх алданги зэрэг нийт 530,601.9 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнээс нөлөөлсөн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэлд 2019-2020 онуудын 816,986.8 мянган төгрөгийн барьцаа хөрөнгө байгаа бөгөөд нийт өр төлбөрийн 74.8 хувийг эзэлж байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 47,237,914.7 мянган төгрөг болж 499,794.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 416,504.3 мянган төгрөг, өмнөх оны үр дүнд залруулсан 83,289.8 мянган төгрөг зэргээр нэмэгдсэн байна.

Сангийн яамны санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого өмнөх оноос 31,745,399.5 мянган төгрөгөөр буюу 34.8 хувиар буурсан байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 31,793,692.2 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан хөрөнгийн санхүүжилт 14,731,183.7 мянган төгрөг, хөрөнгийн төвлөрүүлэх шилжүүлэг 21,067,563.5 мянган төгрөгөөр тус тус буурсан бол тайлант онд үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 1,844,409.7 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн орлого 2,215,770.1 мянган төгрөгөөр тус тус өсөж тайлагнагджээ.

Нийт зардал өмнөх оноос 2,230,336.9 мянган төгрөгөөр буурсан байна. Тухайлбал: бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж 13,988,546.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 1,956,932.5 мянган төгрөг, засгийн газрын гадаад шилжүүлэг 522,763.2 мянган төгрөгөөр тус тус буурч, цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 1,017,002.7 мянган төгрөг, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал 222,971.3 мянган төгрөг, хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалтай хөрөнгийн зардал 11,923,684.2 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн орлого зардал өмнөх оноос буурсан нь Ковид-19 цар тахлаас шалтгаалан Засгийн газрын шийдвэрээр бүх нийтийг хамарсан хөл хорионы

дэглэм тогтоосноос тайлант онд хэрэгжүүлэхээр тусгасан хөтөлбөр, арга хэмжээ хангалтгүй хэрэгжсэнтэй холбоотой байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус яамны 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 16,939,893.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас 313,935.9 мянган төгрөгөөр төсвийн төслийг нэмэгдүүлж, 17,253,829.5 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн төсөлд төсөвлөсөн дүнгээс материаллаг өөрчлөлт гарсан зардлын үзүүлэлтийг дурдвал цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 1,565,273.2 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 211,311.9 мянган төгрөг, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшуулал 361,100.0 мянган төгрөг, тэтгэвэрт гаргахад олгох нэг удаагийн тэтгэмж 40,000.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн бол бараа үйлчилгээний бусад зардал 1,555,810.1 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 284,999.9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамж 111,603.8 мянган төгрөг, томилолт 50,650.6 мянган төгрөгөөр тус тус буурч батлагдсан байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 19 арга хэмжээг санхүүжүүлэхээр 17,253,829.5 мянган төгрөгийн төсөв батлагдаж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 13,603,525.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, 10,905,034.7 мянган төгрөгийг зарцуулж, 2,698,490.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 10,905,034.7 мянган төгрөг буюу 63.2 хувь, зарцуулагдаагүй үлдэгдэл 6,348,794.7 мянган төгрөг байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн сургалт семинарын арга хэмжээ 111,931.1 мянган төгрөг, Олон Улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж 2,316,985.5 мянган төгрөг, төсөл арга хэмжээний бэлтгэл хангах зардал 685,865.9 мянган төгрөг, хөтөлбөрт суурилсан төсвийн төсөл арга хэмжээ 216,748.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Батлагдсан төсвөөс 6,348,794.7 мянган төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй байгаа нь дараах голлох шалтгаантай байна. Тухайлбал:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 1,300,173.6 мянган төгрөг;
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 187,847.8 мянган төгрөг;
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 1,391,139.5 мянган төгрөг;
- Бараа үйлчилгээний бусад зардал 1,031,036.7 мянган төгрөг;
- Засгийн газрын гадаад шилжүүлэг 2,320,093.3 мянган төгрөгөөр тус тус зарцуулалт гараагүйтэй холбоотой байна.

## Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Засгийн газрын нөөц сангаас Засгийн газрын тогтоолоор 2,215,770.1 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 101,260.2 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 28,222.5 мянган төгрөг, нийт 2,345,252.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс Засгийн газрын тогтоолоор зарцуулсан 2,215,770.1 мянган төгрөг, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх сургалтад 26,298.7 мянган төгрөг, туслах малчны өвөлжилтийн бэлтгэл ажилд 7,614.0 мянган төгрөг, цахим архив бүрдүүлэх гэрээт ажиллагсдын цалинд 39,425.1 мянган төгрөгийг тус тус зарцуулж, үлдэгдэл 56,144.9 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд мэдээлбэл зохих 195 мэдээллээс 152 мэдээллийг хугацаандаа, 40 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, үйлчилгээ болон цалингийн зардлаас бусад орлого, зарлагын 59 ажил гүйлгээг огт мэдээлээгүй байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 194,420.7 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилт 95.0 хувьтай байна

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 8,726,511.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 8,324,075.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 1 албан шаардлага хүргүүлж, 402,435.8 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Төсөл хөтөлбөрөөс хүлээн авсан машин тоног төхөөрөмж, программ хангамжийг 106,556.1 мянган төгрөгөөр илүү дүнгээр орлогод авч, үнэ төлбөргүй орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн;
2. Тайлант онд машин тоног төхөөрөмжийн элэгдлийн зардлыг 1,006,180.0 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн;
3. Тавилга эд хогшил, программ хангамжийн элэгдлийн зардлыг тайланд онд 3,948.6 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн;
4. Өмнөх онд үүссэн байгууллагад төлөх барьцаа хөрөнгийн 83,289.7 мянган төгрөгийн өглөгийг чөлөөлж, барилга дансыг капиталжуулан бүртгэхдээ тайлант хугацааны орлого, зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнасан;

5. Тайлант хугацаанд бичсэн дансны буруу бичилтийг залруулснаас бичиг хэргийн зардал 326.2 мянган төгрөг, аж ахуйн материал худалдан авах зардал 60.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 253.4 мянган төгрөг, үндсэн хөрөнгийн гарз 522.0 мянган төгрөг, тайлант оны үр дүн 1,192,077.2 мянган төгрөгөөр тус тус буурч залруулсан;
6. Бусад эргэлтийн хөрөнгөд бүртгэсэн яамны барилгын засварын зардлыг барилга байгууламж дансанд капиталжуулахдаа дансны бичилтийг буруу хийснээс үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз 2,965,340.7 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 2,965,430.7 мянган төгрөг, нийт 5,930,861.4 мянган төгрөгөөр тус тус илүү бүртгэсэн байсныг тус тус санхүүгийн тайланд залруулга хийлгэв.

### **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Шилэн дансны цахим хуудсанд нийт 192 мэдээлэл байршуулснаас 40 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, үйлчилгээ болон цалингийн зардлаас бусад орлого, зарлагын нийт 59 ажил гүйлгээг огт мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.4.5-д “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр мэдээлэх”, санхүүгийн тайлангийн Иж бүрэн байх “Аж ахуйн нэгж, байгууллага тайлант хугацаанд гарсан бүх ажил гүйлгээ, үлдэгдэл буюу үйл явдал, нөхцөл байдлуудаас бүртгээгүй, нэмж тодруулаагүй, орхигдуулсан зүйлсгүй байх”, Үнэн зөв байдал “Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх” батламж мэдэгдэлтэй тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 402,435.8 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 5 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд**

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тушаалыг баримтлан тайлант онд татан буугдсан Бичил санхүүгийн хөгжлийн сангаас 302,467.5 мянган төгрөг, 4 төсөл хөтөлбөрөөс 1,942,508.3 мянган төгрөг, нийт 2,244,975.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлэн хандиваар хүлээн авсан байна.

#### **4. Менежментийн захидал**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### **1. Балансын данстай холбоотой асуудал**

###### **1.1. Илрүүлэлт:**

Бараа материалын эцсийн үлдэгдлийг тооллогоор баталгаажуулсан дүн рүү хөөн шалгаж, тулган баталгаажуулахад бэлэн бүтээгдэхүүн 902.1 мянган төгрөг, аж ахуй материал 117.0 мянган төгрөгөөр тус тус тооллогын дүнгээс зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”; Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2-т “Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана”, санхүүгийн тайлангийн Үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй тус тус нийцэхгүй байна.

###### **1.2. Эрсдэл:**

Бүртгэлээр тавих хяналт сул, хөрөнгө дутагдах;

###### **1.3. Өгсөн зөвлөмж:**

Хөрөнгийн тооллогыг бодитой хийж, үнэн зөв баримтжуулан үр дүнг нэгтгэх;

###### **1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

##### **2.Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал**

###### **2.1. Илрүүлэлт:**

Бэлэг дурсгалын зүйлсийг нэгжийн үнэ 187.5-550.0 мянган төгрөгийн хооронд худалдан авч бэлтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 1999 оны 198 дугаар тогтоолоор баталсан "Бэлэг дурсгалын зүйл гардуулах, хүлээн авах, тайлагнах, зарцуулах журам"-ын 2.3 хэсэгт заасан заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

###### **2.2. Эрсдэл:**

Засгийн газрын тогтоол хэрэгжихгүй байх, төсөвт зардал хэтрэх;

###### **2.3. Өгсөн зөвлөмж:**

Бэлэг дурсгалын зүйл гардуулахад зарцуулах үнийн хязгаарыг холбогдох журамд нийцүүлэн мөрдөж ажиллах;

###### **2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

### **3. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл**

#### **3.1. Илрүүлэлт:**

Төсвийн гүйцэтгэлийн тайланг зөвхөн эдийн засгийн ангиллаар гаргаж ирүүлсэн бөгөөд Төсвийн тухай хууль, Сангийн сайдын баталсан маягт аргачлалын дагуу хөтөлбөр, арга хэмжээний төсөв, гүйцэтгэлийн биелэлт, хүрсэн үр дүн түүний танилцуулга, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэл, нэмэлт санхүүжилтийн тайлангийн танилцуулгыг хуулиар заасан хугацаанд иж бүрэн хийж ирүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйл 54.5-д “Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна”; 54.5.1-д “Тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл /нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр/”; 54.5.3-д “Тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл; 54.5.4-д хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/; 54.5.5-д “Нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга”; Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар батлах журмын 2 дугаар хавсралт; Сангийн сайдын 2012 оны 76 дугаар тушаалаар баталсан Төсвийн гүйцэтгэлийн тайлан боловсруулах журмын 1 дүгээр хавсралт 1.4-д “Төсвийн эрх захирагч нь төсвийн гүйцэтгэлийн тайланд тайлант оны төсвийн хэтрэлт, хэмнэлт түүнд нөлөөлсөн хүчин зүйлийн талаарх дэлгэрэнгүй тайлбар танилцуулга хавсаргана”, 2.3-д “Төсвийн байгууллага нь төсвийн гүйцэтгэлийн тохируулгыг Төсвийн гүйцэтгэлийн тохируулгын 1 а маягтын дагуу гарган төсвийн гүйцэтгэлийн тайлангийн хамт дээд шатны төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

#### **3.2. Эрсдэл:**

Төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан маягтын дагуу боловсруулаагүй байх, хөтөлбөр арга хэмжээг үнэлэх боломжгүй байх;

#### **3.3. Өгсөн зөвлөмж:**

1. Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтын дагуу төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсгийг иж бүрэн гаргаж хэвших;

2. Төсвийн тухай хууль, Сангийн сайдын тушаалуудаар батлагдсан журмуудын дагуу санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангуудад тодруулга, танилцуулга тайлбар бэлтгэж жилийн санхүүгийн тайлантай хамт ирүүлж байх;

#### **3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

### **4. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл**

#### **4.1. Илрүүлэлт:**

Монгол Улсын 2020 төсвийн хуулиар Сангийн яаманд хөрөнгө оруулалтын зардал батлагдаагүй боловч Татварын ерөнхий газрын урсгал зардлаас 2020 оны 9 дүгээр сард худалдан авсан 159,200.0 мянган төгрөгийн өртөгтэй тоёота Гранвиа автомашиныг ТӨБЗГ-ын 2020 оны А/1/1612 тоот албан бичгээр балансаас балансад шилжүүлэн авсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 24 дүгээр зүйлийн 24.6-д “Төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөх, гүйцэтгэлийн хяналт хийхдээ холбогдох норм, норматив, батлагдсан стандарт, зураг

төсвийг үндэслэнэ”, 27 дугаар зүйлийн 27.1-т “Төсвийн төслийг боловсруулахад Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шаардлагаас гадна дараах шаардлага тавигдана 27.1.1-27.1.7”, мөн 27.4-т “Төсвийн удирдамжид дараах зүйлийг тусгана” 27.4.1-27.4.7 заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

#### 4.2. Эрсдэл:

Төсвийн төлөвлөлт үндэслэл муутай хийгдэх, төсвийг бодитой төлөвлөхгүй байх;

#### 4.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийн төслийг үнэн зөв, бодитой тооцоололд үндэслэн боловсруулах, алдаа зөрчлийг дахин гаргахгүй ажиллах.

#### 4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

### **5. Балансын данстай холбоотой асуудал**

#### 5.1. Илрүүлэлт:

Сангийн яам нь 2021 онд төлөх Төрийн сангийн Фрийбаланс программ, экспортын бүтээгдэхүүний үнийн мэдээлэл авах 3 программ, санхүүгийн Acolous программ, хэвлэл захиалгын төлбөр зэрэгт нийт 242,216.7 мянган төгрөгийг урьдчилж төлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т “Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно”, 7.3-т “Төсвийг нэг жилээр баталж, тайлагнах бөгөөд батлагдсан төсвийг сар, улирлаар хуваарилан, хэрэгжилтийг зохион байгуулна, 7.7-д “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ”, Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хууль, санхүүгийн тайлангийн Хэмжилт “Байгууллагын ажил гүйлгээ буюу үйл явдал тайлант хугацаанд зөв дүнгээр бүртгэгдсэн орлого, зардлыг зөв хуваарилсан байх” батламж мэдэгдэлтэй тус тус нийцэхгүй байна.

#### 5.2. Эрсдэл:

Батлагдсан төсөвт зардлыг хэтрүүлэн зарцуулах;

#### 5.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийг мөрдөж, тухайн жилд батлагдсан төсөвт зардлыг санхүүжүүлж, дараа оны зардлыг урьдчилан төлөхгүй байх;

#### 5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Сангийн яамны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020			САГ-2021./306/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Сангийн яам		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Шилэн дансны цахим хуудсанд нийт 192 мэдээлэл байршуулснаас 40 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, үйлчилгээ болон цалингийн зардлаас бусад орлого, зарлагын нийт 59 ажил гүйлгээг мэдээлээгүй байна.		Албан шаардлага	Төрийн нарийн бичгийн дарга, Нягтлан бодогч	С.Наранцогт, Б.Мягмарсүрэн
2	Бараа материалын эцсийн үлдэгдлийг тооллогоор баталгаажуулсан дүн рүү хөөн шалгаж, тулган баталгаажуулахад бэлэн бүтээгдэхүүн 902.1 мянган төгрөг, аж ахуй материал 117.0 мянган төгрөгөөр тус тус тооллогын дүнгээс зөрүүтэй байна.	1,019.1	Зөвлөмж өгөх	Төрийн нарийн бичгийн дарга, Нягтлан бодогч	С.Наранцогт, Б.Мягмарсүрэн
3	Бэлэг дурсгалын зүйлсийг нэгжийн үнэ 187.5-550.0 мянган төгрөгийн хооронд худалдан бэлтгэсэн.		Зөвлөмж өгөх	Төрийн нарийн бичгийн дарга, Нягтлан бодогч	С.Наранцогт, Б.Мягмарсүрэн
4	Төсвийн гүйцэтгэлийн тайланг зөвхөн эдийн засгийн ангиллаар гаргаж ирүүлсэн бөгөөд Төсвийн тухай хууль, Сангийн сайдын баталсан маягт аргачлалын дагуу хөтөлбөр, арга хэмжээний төсөв, гүйцэтгэлийн биелэлт, хүрсэн үр дүн түүний танилцуулга, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэл, нэмэлт санхүүжилтийн тайлангийн танилцуулгыг хуулиар заасан хугацаанд иж бүрэн хийж ирүүлээгүй байна.		Зөвлөмж өгөх	Төрийн нарийн бичгийн дарга, Нягтлан бодогч	С.Наранцогт, Б.Мягмарсүрэн
5	Монгол Улсын 2020 төсвийн хуулиар Сангийн яаманд хөрөнгө оруулалтын зардал батлагдаагүй боловч Татварын ерөнхий газрын урсгал зардлаас 2020 оны 9 дүгээр сард худалдан авсан 159,200.0 мянган төгрөгийн өртөгтэй тоёота Гранвиа автомашиныг ТӨБЗГ-ын 2020 оны А/1/1612 тоот албан бичгээр балансаас балансад шилжүүлэн авсан.	159,200.0	Зөвлөмж өгөх	Төрийн нарийн бичгийн дарга, Нягтлан бодогч	С.Наранцогт, Б.Мягмарсүрэн
6	Сангийн яам нь 2021 онд төлөх Төрийн сангийн Фрийбаланс программ, экспортын бүтээгдэхүүний үнийн мэдээлэл авах 3 программ, санхүүгийн Acolous программ, хэвлэл захиалгын төлбөр зэрэгт нийт 242,216.7 мянган төгрөгийг урьдчилж төлсөн байна.	242,216.7	Зөвлөмж өгөх	Төрийн нарийн бичгийн дарга, Нягтлан бодогч	С.Наранцогт, Б.Мягмарсүрэн
<b>ДҮН</b>		<b>402,435.8</b>			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25 № 207/А0160061  
САГ 2021/306/СТА-ТЦЗ  
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Сангийн яамны 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд нийт 192 мэдээлэл байршуулснаас 40 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, үйлчилгээ болон цалингийн зардлаас бусад орлого, зарлагын нийт 59 ажил, гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4.5-д "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр мэдээлэх", санхүүгийн тайлангийн Үнэн зөв байдал, Иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдэлтэй тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хууль тогтоомжийн дагуу мэдээллийг хугацаанд нь үнэн зөв, иж бүрэн байршуулж мэдээлэх биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт, ерөнхий нягтлан бодогч Б.Мягмарсүрэн нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

*Ц.Наранчимэг*  
*П.Чанцалдулам*

Ц.НАРАНЧИМЭГ

П.ЧАНЦАЛДУЛАМ

## ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing.

